

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН “НҮҮДЭЛЧИН МОНГОЛ -2022” ДЭЛХИЙН
СОЁЛЫН ФЕСТИВАЛЬ НААДМЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН
ТУХАЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Дархан-Уул аймаг

2022.08.19

Д/д	Гүйцэтгэсэн үйл ажиллагааны нэр: НҮҮДЭЛЧИН МОНГОЛ-2022 НААДАМ ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР 1 дүгээр шат 7 дугаар сарын 10нд, 2 дугаар шат 8 дугаар сарын 12-14 өдрүүдэд
1	Гарчиг: Дархан-уул аймгийн Нүүдэлчин Монгол-2022 Дэлхийн соёлын фестиваль
2	<p>Хамрах хүрээ:</p> <p>Аймгийн Засаг даргын орлогч Б.Жавхлангаар батлуулсан ажлын хэсгийн удирдамж 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдөр гарч 7 дугаар сарын 10-ний өдөр Дархан суманд” Нүүдэлчин Монгол” соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын наадмын 1 дүгээр шалгаруулалтыг 7 ай саваар 100 гаруй хүн оролцуулан зохион байгуулж 39 өвлөн уламжлагчийг 2 дугаар шатанд 6 ай саваар шалгаруулж авсан. Нүүдэлчин Монгол наадам 1 дүгээр шатны шүүгчдийн бүрэлдэхүүнд: Наадмын ерөнхий шүүгчээр Урлаг судлаач, ахмад ажилтан Г.Нарангэрэл, Шүүгчээр Монгол Улсын гавьяат жүжигчин Г.Алтанцэцэг, Зураач, урчуудын холбооны тэргүүн Н.Хишигбаатар, Соёл, урлагийн газрын урлаг, уран бүтээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Ц.Отгонбаяр нар ажиллалаа.</p> <p>Оролцогч байгууллагууд Аймгийн Засаг даргын тамгын газар, Соёл, урлагийн газар, Аймгийн Хөгжлийн бодлогын хэлтэс, Дархан сумын Засаг даргын Тамгын газар, Залуучууд театр, Аймгийн Музей, Хүүхдийн номын ордон, Төв номын сан, Аймгийн тогоочдын холбоо, Аймгийн зураач урчуудын эвлэл, Сумдын Засаг даргын Тамгын газар, Сумдын соёлын төвүүд, Цайны их зам ХХК, Амгалан заяа ХХК, Бадрах мишээл, Элит хөгжил ХХК хамтарч оролцов.</p>
3	<p>Үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайлан, дүгнэлт:</p> <p>Нүүдэлчин Монгол наадмын 1 дүгээр шатны бэлтгэл ажлын төлөвлөгөөг 6 дугаар сарын 30-ний өдөр гаргаж, 2 дугаар шатны бэлтгэл ажлын төлөвлөгөөг 7 сарын 20-ны өдөр батлуулж, төлөвлөгөөний дагуу бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэв. Төлөвлөгөөнд: Өвлөн уламжлагчдын отог болон тайзны хөтөлбөрийн бэлтгэл ажил, наадамтай холбоотой төсөв гаргаж батлуулах, отог гэр бэлдэх, отог гэрт байрлах эдлэл хэрэглэлийг бэлтгэх бусад ажлуудыг хийж гүйцэтгэсэн. "Нүүдэлчин Монгол-2022" дэлхийн соёлын фестивалд амжилттай оролцож ганзага дүүрэн 3 оролцогч шилдэг өвлөн уламжлагчаар тодорсон. Үүнд:</p> <p>Аймгийн Засаг даргын орлогч Б.Жавхлангаар ахлуулсан нийт 61 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон бөгөөд Язгуур урлагийн багт бага насны өвлөн уламжлагч 6 хүүхэд, Монгол Улсын Соёлын тэргүүний 9 ажилтан, зургаан Ардын авьяастан нийт 26 Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчид оролцсон. Үүний дотор сүүлийн 10 гаруй жил 1000 гаруй хүүхдийг бий биелгээгээр шавилан сургаж буй Монгол</p>

	<p>Улсын шилдэг өвлөн уламжлагч, Баядын алдарч бийч Жамьян гуайн охин, МУСТА, Нүүдэлчин Монгол анхдугаар наадмыг “Төгс эзэмшсэн өвлөн уламжлагч” Дэжидмаа, МУСТА, Ерөөлч магтаалч Дүйнхэрсүрэн, хулсан хуурч Жавзанжав нарын олон сайхан Ардын авьяастнууд соёлын биет бус өвөө сурталчлан оролцлоо. Мөн Дархан-Уул аймгийн зураач урчуудын холбооны тэргүүн Н.Хишигбаатараар ахлуулсан соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч, уран хайчилбарч Б.Төмөрхуяг, Монгол зураач Т.Жаргалсайхан, Монгол дархан, сийлбэрч Г.Эрдэнэтөгс, Н.Авдукалик, Н.Дижан нар гар урлалын гайхамшигт бүтээлүүдээрээ тус тус оролцсон. Дархан-Уул аймгийн Соёлын биет бус өвийн өргөөнд “Монгол гайхамшиг” уралдааны хамгийн ой тогтоолт сайтай хүнээр тодорсон, баяр наадам, зан үйл, ёс, тоглоом наадгай, уриа дуудлага оньсон тоглоомын өвлөн уламжлагч Л.Алтангэрэл, 3000- гаад хүнд соёлын биет бус өвөө сурталчлан таниулж өвлүүлэн уламжлуулж буй Мөнхтуяа, Монгол Үндэсний бичиг соёлыг түгээн дэлгэрүүлэх судлан сурталчлах үйлсийг дэлгэрүүлэгч Ж.Эрхэмсайхан, Б.Булганчимэг нар Хүн төрөлхтний бичиг соёлын давтагдашгүй өв соёлоо сурталчлан таниулсан. Арьс шир, алт мөнгөн эдлэл, бэлэг дурсгалын чиглэлээр үйл ажиллагаа явуулан, чанар, өнгө үзэмжийг эрхэмлэсэн төгс бүтээлийг урласаар ирсэн “Цайны их зам” ХХК тэргүүтэй эсгий бүтээгдэхүүн урлаачид, уламжлалт цагаан идээ ундаа үйлдвэрлэгчид болон Дархан-Уул аймгийн Тогоочдын холбооны мастер тогооч нар зэрэг өргөн бүрэлдэхүүнтэй наадамдаа оролцож ганзаг дүүрэн ирсээн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ Соёлын бүтээлч үйлдвэрлэл нэвтрүүлсэн төрөлд- “Монгол бичиг QR код” бүтээлээр багш Б.Булганчимэг, ➢ Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд” төрөлд багш Ж.Эрхэмсайхан, ➢ "Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйл" төрөлд багш Ц.Буянхишиг нар шалгарч ШИЛДЭГ ӨВЛӨН УЛАМЖЛАГЧ МЕДАЛЬ тус бүр 1.000.000 төгрөгөөр шагнуулсан.
4	Хавсралт (Холбогдох гэрэл, зураг, дүрс бичлэгийг хавсаргах)
5	<p>Санал, хүсэлт:</p> <p>Наадамд оролцогчдын амрах байр отог гэрийн зайг ойртуулах. Зөөж тээвэрлэх унаа тэрэгний асуудал дээр анхаарах. Өндөр настай оролцогчдыг отог гэр унаанд суух газар хүртэл явган явуулахгүй байх. Тогоочдын холбооноос оролцож буй оролцогчдыг өвлөн уламжлагчдын тооноос тусад нь гаргаж өвлөн уламжлагч, зохион байгуулагчдын тоог нэмэх, үзэгчдийн саналыг нэгдсэн тоонд оруулахгүй байх зэргээр шалгаруулах.</p>
6	Тайланг хянасан: Соёл, урлагийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч: Х.Соёл-Эрдэнэ



Зураг.1 Отог гэр: Соёлын биет бус өвийг сурталчилах,
Хүндэтгэлийн гэр, Ардын язгуур урлагийн гэр, Гар урлалын гэр



Зураг. 2 Ардын язгуур урлагийн гэр



Зураг.3 Соёлын биет бус өвийг сурталчилах гэр



Зураг. 4 Соёлын бүтээлч үйлдвэрлэл нэвтрүүлсэн төрөлд- "Монгол бичиг QR код" бүтээлээр багш Б.Булганчимэг, Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд" төрөлд багш Ж.Эрхэмсайхан,"Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйл" төрөлд багш Ц.Буянхишиг